



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn


2024.04.30 № 1/2214

танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОДГЭРЭЛ ТАНАА

Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар нарын санаачлан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлснийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

Судалж, саналаа яаралтай ирүүлнэ үү.



Б.ЭНХБАЯР

1516018-6
Doc.yam a5.2024



Г ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Б.ЭНХБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жамжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn


2024.04.13 № ХЭТ/ВН
танай _____-ны № _____-т

Санал, дүгнэлтийн төсөл
бэлтгэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар нараас Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачлан боловсруулж, Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу санал, дүгнэлтийн төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг хүсье.

Хавсралт: 4 хуудастай.



МОНГОЛ УЛСЫН САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Д.АМАРБАЯСГАЛАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Дамдины ЦОГТБААТАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жамжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-69-72, Факс: 32-70-16
E-mail: tsogtbaatar@parliament.mn
http://www.parliament.mn

2024.04.13 № ЧИТ-03/3118
танай _____-ны № _____-т

Г Хуулийн төсөлд санал авах тухай

Иргэдээс цахим парламентаар ирсэн саналыг үндэслэн Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шүүхийн нээлтэй, ил тод байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу Танд хүргүүлж байна. Хуулийн төслийн талаарх Засгийн газрын саналыг зохих журмын дагуу ирүүлнэ үү.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ЦОГТБААТАР
Г.ЗАНДАНШАТАР
Д.ТОГТОХСҮРЭН

Н.УЧРАЛ

0000000038

000245008756

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАЗАР ШҮҮХ

Г.ЗАНДАНШАТАР

Д.ТОГТОХСҮРЭН

Н.УЧРАЛ

Д.ЦОГТБААТАР

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2024 оны "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 18 дугаар тогтоолын 1 дэх заалтад "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан дараах асуудлыг судлан холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн боловсруулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэ-т даалгасгай." гэж, мөн заалтын 5 дугаарт "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг боловсронгуй болгох" гэж заасан.

Улсын Их Хурлаас 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт бүхий Долдугаар¹ бүлэг шинээр нэмж баталсан бөгөөд тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг маргаан нь нийт иргэний хэрэг маргааны 50 орчим хувийг эзлэхээр байх ба Иргэний хэрэг хянан шүүхэд шийдвэрлэх тухай хуулийн 75² дугаар зүйлийн 75².1-д "Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ." гэж заасан. Үүнийг хэрэгжүүлэх хүрээнд цаасан баримтыг цахим баримтаар хөрвүүлэхтэй холбогдох хуулийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай юм.

Улсын Их Хурлын 2024 оны "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 05 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1 дүгээрт "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгах талаар

хуулийн төсөл боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж заажээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6-д "Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр нэвтрүүлж болох бөгөөд холбогдох журмыг Ерөнхий зөвлөл батална." гэж, 71 дүгээр зүйлийн 71.1.12-т "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн систем, цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулах програм хангамжийг хөгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах" гэж, 71.1.14-д "шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэг хийх, архивлах болон шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журмыг хуульд заасны дагуу батлах" гэж, 71.1.27-д "цахимаар хийсэн худалдаа, цахим орчинд хийсэн гэрээ, хэлцэл, интернэт үйлчилгээ, интернэт орчинд анх удаа хэвлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн талаар маргаан, интернэтэд нийтлэгдсэн буюу түгээсэн бүтээлийн зохиогчийн эрх буюу бусад холбоотой эрхийг зөрчсөнтэй холбоотой маргаан, интернэтийн домэйн нэр, эзэмшил, түүний эерчилтэй холбоотой маргааныг тухайлан хуульд заасан тохиолдолд цахим шүүхээр шийдвэрлэх платформ, эсхүл шүүх хуралдааныг цахимаар хэрэгжүүлэх программ хангамжийг хөгжүүлэх" гэж заасан байна.

Мөн 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2021 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хууль нь шүүх эрх мэдлийн салбарын шинэтгэлийг гүнзгийрүүлэх томоохон үе шат болсон бөгөөд тус хуульд шүүхийг цахимжуулах, цахим шүүхийг хөгжүүлэх асуудлыг хуульчилсан байна.

1.2.Практик шаардлага

1.Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байх, шүүх хуралдааныг цахимаар нэвтрүүлэх эрх зүйн үндэслэлийг Монгол Улсын шүүхийн тухай хуулиар зохицуулсан хэдий ч тус асуудлыг хэрхэн хэрэгжүүлэхтэй холбогдох журам гараагүй буюу өмнөх хуулийн хүрээнд мөрдөж байсан хуучин журмууд хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журмаар шүүхийн зүгээс шүүх хуралдааныг шууд дамжуулах бус өргөн нэвтрүүлгийн буюу хэвлэл мэдээллийн байгууллага, тэдгээрийн ажилтан дамжуулахтай холбогдох асуудлыг журамласан байх бөгөөд төр, байгууллага, хувь хүний нууц, насанд хүрээгүй этгээдэд холбогдох эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг цахимаар мэдээлэхийг хоригложээ.

Хувь хүний болон байгууллагын нууцын тухайд шүүх хуралдааныг цахимаар дамжуулахад тавигдах хязгаарлалтыг Монгол Улсын Шүүхийн тухай хуульд төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийн хүрээнд тодорхойлсон байна.

Төрийн болон албаны нууцыг хамгаалах харилцааг Монгол Улсын Үндсэн хуулиар бэхжүүлсэн байх ба Төрийн болон албаны нууцын тухай хуулиар хамгаалагдсан байдаг.

Дээрх хууль тогтоомжоос үзвэл Монгол Улс нээлттэй шүүх хуралдааныг цахимаар нэвтрүүлэн, шууд дамжуулалт хийх эрх зүйн үндсийг тавьсан хэдий ч хувь хүний эмзэг мэдээлэл, байгууллагын нууц, төрийн болон албаны нууцыг задруулахыг хориглосон зохицуулалтуудыг хууль тогтоомжид тусгасан байна.

бичгийг хүлээн авах боломжгүй байгаагаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад үүнийг баталгаажуулсан зохицуулалтгүйгээс хэрэгжих боломжгүй байна.

Үүнээс үзэхэд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаасан болон цахим хосолмол хэлбэрээр явуулах практик шаардлага нэгэнт бий болсон байх бөгөөд иргэн өөрөө хүсвэл цахимаар шүүхэд хандах, шүүх хуралдаанд оролцох, баримт материалыг цахимаар гаргаж өгөх зэргээр шүүхийн үйлчилгээг цахимаар авах нөхцөл боломж бүрдсэн байна.

Иймд өнгөрсөн хугацаанд шүүхийн зарим үйл ажиллагааг цахимаар явуулж байсан туршлагад тулгуурлан цахим үндэстэн болох Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-тай уялдуулж шүүхийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, иргэдийн цаг хугацаа, орон зайн хязгаарлалтгүйгээр шүүхэд хандах эрхийг хангах, шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11 дэх хэсэгт "Шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх" гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.6-д "Шүүхийг дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх" гэж тус тус заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 332 дугаар тогтоолоор "Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийн нэвтрүүлэх нэгдсэн бодлого"-ын баримт бичгийг 1 зорилго, 2 зорилт, 13 дэд зорилт, 48 арга хэмжээ, 19 дэд арга хэмжээ, 94 шалгуур үзүүлэлтэйгээр баталсан байна.

Тус бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2024 онд шүүхийн цахим шийдлийн интерпрайз архитектурь гаргах, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд тус ажлын тайланд "...шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх процессын хууль бусад холбогдох хуульд цахимжуулалттай холбоотой эрх зүйн зохицуулалт оруулах, түүнд нийцүүлэн эрх зүйн актуудад шүүхийн цахимжуулалттай холбоотой нэмэлт, өөрчлөлт шинэчлэл хийх шаардлага байна." гэж дүгнэжээ.

Олон улсын түвшинд шүүхийн үйлчилгээний хүртээмжийг хэмжих нэг шалгуур үзүүлэлт нь шүүхийн үйлчилгээний мэдээллийг иргэдэд хүргэх үр өгөөжтэй механизм бүрдүүлэхэд мэдээллийн технологийн дэвшилтэд технологийг ашиглан иргэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран шүүхэд хандах боломжийг бүрдүүлсэн байх явдал юм.

Шүүхийн цахимжилтын талаар гадаад орны сайн туршлагаас дурдвал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 1990 оноос шүүхийн цахимжуулалт эхэлсэн байх бөгөөд 2010 оноос цахим хавтаст хэрэг бий болгох процесс эхэлж одоогоор бүх мужуудад захиргаа, зөрчил, иргэний хэргийг цахим хавтаст хэрэгт бүрэн хөрвүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цахим платформд бүрэн шилжиж байна. Эрүүгийн хэрэг нь Бавари, Хессен мужуудад цахим платформд бүрэн, харин цахим хавтаст хэрэгт дийлэнхи нь шилжсэн байна.

"E-Justice" шүүх, прокурорын нэгдсэн платформ хийж, түүнд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх шүүх, прокурор нэгдсэн байх бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмгөөлөгчид шүүхэд материаллаа цахимаар өгөх үүргийг хуулиар оноожээ.

Иймд шүүх хуралдааныг цахимаар нэвтрүүлэх буюу шууд дамжуулах, бичлэгийг хүргэх, улмаар шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгахад хувь хүний эмзэг мэдээлэл, байгууллагын нууц, төрийн болон албаны нууцыг хамгаалах, олон нийтэд ил тод, нээлттэй байлгах боломж олгосон эрх зүйн уян хатан тодорхой зохицуулалттай болох шаардлагатай юм.

Шүүхийн үйл ажиллагааны олон нийтэд нээлттэй, ил тод байдлын хэлбэрүүдийг тодорхойлох, тэдгээрийг биечлэн болон цахимаар хэрхэн хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, түүнчлэн хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаа цахимаар нээлттэй, ил тод байх, үүнийг хэрхэн, ямар ажиллагаанд хэрэгжүүлэх зэрэг талаар хуульчлах нь хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагааг цахимжуулах харилцааны гол суурь нөхцөл болно.

2. Монгол Улсын шүүхийн байгууллагад 1989 оноос мэдээллийн технологи нэвтрүүлж эхэлсэн байх бөгөөд өнгөрсөн хугацаанд шүүх, шүүхийн Тамгын газарт иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны "Иргэн-2014" нэгдсэн систем, иргэний шүүхийн хэргийн явцын мэдээлэл irgen.civilcourt.mn, "Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем", "Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем", шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn, шүүх хуралдааны явц, тов, тоймыг мэдээлэх цахим систем www.live.shuukh.mn зэрэг 20 гаруй систем, программ хангамж хэрэглэгдэж байна.

2020-2021 онд "Ковид-19" цар тахлын нөхцөл байдлаар холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шүүхээс хэрэг, нэхэмжлэл, гомдлыг цахимаар хүлээн авах, хэргийн оролцогчдыг цахимаар шүүх хуралдаанд оруулах, зарим нотлох баримтыг төрийн эрх бүхий байгууллагуудаас авах, солигдох зэргээр үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг цахимд шилжүүлэн, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж иржээ.

Сүүлийн 5 жилийн статистик тоон мэдээллээр улсын хэмжээнд нийт эрүүгийн хэргийн 18 орчим хувь, иргэний хэргийн 6 орчим хувь нь давж заалдсан¹ байх бөгөөд энэхүү давж заалдах шатны шүүх хуралдааны 50 орчим хувийг цахим шүүх хуралдаан эзэлсэн байна.

Мөн анхан болон давж заалдах шатны шүүхийн хэмжээнд 106 ерөнхий шүүгч, шүүхийн Тамгын газарт 52 албан тушаалтан тоон гарын үсэг хэрэглэж байна.

Шүүхийн эрүү, иргэний хэргийн тусгай архиваас иргэн, хуулийн этгээдэд төндөрийн тодорхойлолт, лавлагаа олгох ажиллагааг цахимаар явуулж байна.

Шүүх "ХУР" төрийн мэдээлэл солилцооны системээс шаардлагатай лавлагаа, тодорхойлолт, мэдээлэл татах "Шүүхийн цахим лавлагааны систем" ашиглалтад оруулсан бөгөөд тус системээр 18 төрлийн мэдээлэл татан авах боломжтой байна. Эдгээр системийг иргэн, захиргааны хэргийн шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа нэвтрүүлснээр бусад төрийн байгууллагаас лавлагаа, тодорхойлолт авдаг цаг хугацаа, зардлыг хэмнэдэг болсон. Уг системийг 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүх шүүхүүдэд нэвтрүүлж эхэлсэн бөгөөд төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системээс 6 багц мэдээллийн хүрээнд 18 багц лавлагаа, мэдээлэл татан цаасаар хэвлэн иргэний болон захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд ашиглаж байна. Зүй нь "ХУР" системээс татсан мэдээлэл, лавлагаа нь цахим баримт бичиг хэлбэрээр үнэлэгдэх боломжтой ч шүүхийн платформ нь эдгээр цахим баримт

¹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс

Шүүхийг цахимжуулах төсөлд тус улсын бүх муж улсын холбогдох байгууллагуудын төлөөлөл бүхий 80 хүний бүрэлдэхүүнтэй баг байгуулагдаж, тус төслийг 2014-2025 онд хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал, Хессен муж улсын шүүх, прокурор 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр бүрэн цахимд шилжихээр байх ба тус улс хуулийн байгууллагуудын цахимжилтийн төслийн зардлын тооцоог 2025 он хүртэл гаргасан нь нийт 250 сая еврогоор төсөвлөгджээ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал, шүүхийн хүний нөөцийн хөдөлгөөн, бүрдүүлэлт, цалин, нэмэгдэл, төсөв зэрэг асуудлаар Монгол Улсын шүүхийн тухай хуульд, шүүхийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг цахим үзүүлэхтэй холбоотойгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд шүүх цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

Иймд хуулийн төслийн саналд шүүх эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулж болох талаар ерөнхий суурь зохицуулалтыг тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг тодорхой болгохоос гадна шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах эрх зүйн орчныг бүрдүүлснээр шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй, ил тод, нээлттэй, шуурхай болгох, бүтээмж, үр дүн дээшлэх, оролцооны хялбар дөт байдал хангагдах, цаг хугацаа хэмнэх, орон зайн хязгаарлалт арилах, эдийн засгийн зардал буурах, шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэх зэргээр тулгамдаж буй олон бэрхшээлийг амжилттай шийдвэрлэхэд эергээр нөлөөлнө.

Хуулийн төсөл батлагдсанаар:

1.Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал тодорхой болох ба ингэснээр иргэдийн шүүхэд итгэх итгэл нэмэгдэнэ.

2.Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнээр зарим хэрэг, маргааныг богино хугацаанд хянан шийдвэрлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалагдаж, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай авах нөхцөл бүрдэнэ.

3."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан цахим үндэстэн болох төрийн үйлчилгээг цахимд шилжүүлэх зорилго, зорилт үе шаттай хэрэгжих нөхцөл бүрдэж, иргэн төвтэй шүүхийн үйлчилгээ төлөвших замаар шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.

4.Цаг үе, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

5.Шүүх, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн төсвийн зардлаас гадна иргэдийн цаг хугацаа, санхүүг хэмнэхэд эерэг нөлөөллийг үзүүлнэ.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, үнэлгээ хийх шаардлагагүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийн төсөлтэй холбогдуулан гарах бусад хууль тогтоомжийн төслийн талаар

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж, уялдсан байх бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг холбогдох шаардлагатай бусад хуулийн төслийг боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална" гэж заасан. Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг "... иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. ..." гэж өөрчлөн найруулсан билээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 2021-2030 онд хэрэгжүүлэх "5.1.Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана." гэсэн зорилтын хүрээнд "3.Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинэ." гэж, мөн Ухаалаг засаглалын чиглэлд "5.1.9.Шүүх үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно.", "5.1.10.Ес зүй, цогц чадамжтай шүүхийн хүний нөөц бэлтгэх суурь тогтолцоог бий болгож, төгөлдөржүүлнэ.", "5.1.11.Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлнэ." гэж шүүх эрх мэдлийн салбар дахь ил тод, нээлттэй байдал, цахимжилтийн хөгжлийг тодорхойлсон.

Түүнчлэн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дахь заалтын 1 дүгээр үе шат (2021-2030)-ны 4-т "Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирна." гэсэн зорилтыг хангахад салбаруудын цахимжилтийн уялдаа холбоог хангах асуудал чухал байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.6.2.3-т "Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, буедад шилжүүлэхийг хориглоно." гэж, 3.6.3.3-т "Төрийн өгөгдөл мэдээллийг ангилж, үнэ цэнийг тогтоох, бүртгэх, хадгалах, дамжуулах, шилжүүлэх, хяналт тавих эрх эзний зохицуулалтыг тодорхой болгож мөрдөнө." гэж, 3.6.4.1-д "Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана." гэж заасан.

Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай хуулиудыг баталснаар Төрийн аливаа байгууллага нээлттэй, ил тод байдлыг хангах, хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим засгийг бэхжүүлэх эрх зүйн орчинд ахиц гарсан.

Шүүхэд цахимжилт, шинэ техник, технологи нэвтрүүлэх, цаашид хэрэгжилтийг хангахад шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж буй шүүгчдийн үүрэг оролцоо, манлайлал чухал юм. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын 6.3-т "Шүүгч нь шүүгчийн мэдлэг, ур чадвар, хувийн чанарыг дээшлүүлэх, сайжруулах зохих арга хэмжээг тухай бүр авах бөгөөд энэ зорилгоор шүүгчийн албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай шүүхийн сургалт, бусад арга хэрэгслийг зохих ёсоор бүтээгчээр ашиглана." гэж тусгасан нь шүүгч орчин үеийн техник, технологийг хөл нийлүүлэн алхах, энэ талаарх мэдлэг, боловсрол, чадвараа байнга дээшлүүлэх үүрэгтэйг онцолсон. Шүүгчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэхэд шүүхийн сургалтын байгууллагын тогтолцоо, бүтэц, эрх зүйн байдлыг улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байна.

Улсын Их Хурлын 2024 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг боловсронгуй болгох асуудлыг судлан холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод, нийцүүлэн боловсруулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна. Улсын Их Хурлаас 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт бүхий Додугаар бүлэг шинээр нэмж баталсан. Энэ хууль 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ. Тусгайлан журмаар хянан шийдвэрлэх хэрэг маргаан нь нийт иргэний хэрэг маргааны 50 орчим хувийг эзлэхээр байгаа бөгөөд Иргэний хэрэг хянан шүүхэд шийдвэрлэх тухай хуулийн 752 дугаар зүйлийн 752.1-д тусгайлан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэхээр заасан. Үүнийг хэрэгжүүлэх хүрээнд цаасан баримтыг цахим баримтаар хөрвүүлэх, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулахтай холбогдох эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай.

Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх, цахимжилтийг нэвтрүүлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай тул Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүхийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах, шүүхийн үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдлыг дээшлүүлэхэд цахимжилтийг эрчимтэй нэвтрүүлэх, цахимжсан шүүхийн орчинд шүүхийн хүний нөөцийн оновчтой, зохистой удирдлагаар хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор Монгол Улсын шүүхийн тухай хуульд болон түүнд холбогдуулан Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Төрийн албаны тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсрууллаа.

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйл "Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх" асуудлыг зохицуулсан бөгөөд энэ зүйлийг өөрчлөн найруулах замаар шүүх нээлттэй, ил тод байх арга зам буюу хэлбэрийг нарийвчлан зохицууллаа. Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг сонирхогч этгээд бичлэн болон цахимгаар танилцах боломж бүрдэнэ.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр хуулийн хүрээнд шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэхээр харилцааг тухайлан тусгалаа. Ингэхдээ нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудас, эсхүл шүүхийн нээлттэй бусад цахим платформд заавал байршуулж олон нийт бодит мэдээллийг цаг тухайд нь, шуурхай авах боломжоор хангагдана.

Ямар ч тохиолдолд авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг нээлттэй хийхээр тусгалаа. Харин хуульд заасан тодорхой тодорхой тохиолдлоос гадна шүүх хуралдааныг нээлттэй хийх нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журамд аюул учруулах эрсдэлтэй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шаардлагатай зэрэг зайлшгүй шалтгааны нөхцөл үүсээл шүүх хуралдааныг хаалттай явуулах эсэхийг шүүх бүрэлдэхүүн тухайлан шийдвэрлэхээр зохицууллаа.

Шүүх хуралдааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон нийт үнэн бодит мэдээллийг авах боломжийг тэгш хангахад шүүхэд цахим архив, систем, платформыг хөгжүүлэх талаар мөн тусгав.

2. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагын үйлчилгээ цахимжиж, иргэдэд ойртон, шуурхай болсоор байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.4-т зааснаар шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй, нээлттэй, ил тод байх зарчимд тулгуурладаг.

Шүүхийн үйлчилгээнд цахимжилт тодорхой түвшинд нэвтэрсэн боловч шүүхийн хуралдааныг зарим үед цахимаар хийх болон шүүхийн захиргааны цахим системийн хөгжүүлэлтийн хүрээнд явагдаж байна. Тухайлбал, сүүлийн 5 жилийн статистик тоон мэдээллээр улсын хэмжээнд нийт эрүүгийн хэргийн 18 орчим хувь, иргэний хэргийн 6 орчим хувь нь давж заалдсан байх бөгөөд энэхүү давж заалдах шатны шүүх хуралдааны 50 орчим хувийг цахим шүүх хуралдаан эзэлсэн байна. Түүнчлэн 2020-2021 онд "Ковид-19" цар тахлын нөхцөл байдлаар холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шүүхээс хэрэг, нэхэмжлэл, гомдлыг цахимаар хүлээн авах, хэргийн оролцогчдыг цахимаар шүүх хуралдаанд оруулах, зарим нотлох баримтыг төрийн эрх бүхий байгууллагуудаас авах, солилцох зэргээр үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг цахимд шилжүүлэн, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж иржээ.

Түүнчлэн шүүх "Хур" төрийн мэдээлэл солилцооны системээс шаардлагатай лавлагаа, тодорхойлолт, мэдээлэл татах "Шүүхийн цахим лавлагааны систем" ашиглалтад оруулсан бөгөөд тус системээр 18 төрлийн мэдээлэл татан авах боломжтой байна. Эдгээр системийг иргэн, захиргааны хэргийн шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа нэвтрүүлснээр бусад төрийн байгууллагаас лавлагаа, тодорхойлолт авдаг цаг хугацаа, зардлыг хэмнэдэг болжээ. Уг системийг 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүх шүүхүүдэд нэвтрүүлж эхэлсэн байх бөгөөд төрийн мэдээлэл солилцооны "Хур" системээс 6 багц мэдээллийн хүрээнд 18 багц лавлагаа, мэдээлэл татан цаасаар хэвлэн иргэний болон захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд ашиглаж байна.

"Хур" системээс татсан мэдээлэл, лавлагаа нь цахим баримт бичиг хэлбэрээр үнэлэгдэх боломжтой ч шүүхийн платформ нь эдгээр цахим баримт бичгийг хүлээн авах боломжгүй байгаагаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад үүнийг баталгаажуулсан зохицуулалтгүйгээс хэрэгжих боломжгүй байна. Үүнээс

үзэхэд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаасан болон цахим хосолмол хэлбэрээр явуулах практик шаардлага нэгэнт бий болсон байх бөгөөд иргэн өөрөө хүсвэл цахимаар шүүхэд хандах, шүүх хуралдаанд оролцох, баримт материалыг цахимаар гаргаж өгөх зэргээр шүүхийн үйлчилгээг цахимаар авах нөхцөл боломж бүрдсэн байна.

Эдгээр нөхцөл байдал нь шүүхийн үйлчилгээнд цахимжуулалтыг бүрэн нэвтрүүлэх боломж байгааг харуулахын зэрэгцээ цаашид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаасан суринаас цахим сууринд хөрвүүлж, цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад эрх зүйн орчин дутагдалтай байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуульд цахимжилттай холбогдуулан дараах өөрчлөлтийг тусгалаа:

- Эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цахимаар явагдана. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах ажиллагааны бэлтгэл хангах, үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор бөгөөд захиргааны хэргийг шүүхэд цахимаар хянан шийдвэрлэх ажиллагааг 2025 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс, эрүү, иргэний хэргийн хувьд 6 сарын дараа буюу 2025 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэхээр тусгалаа.
- Цахимаар хэрэг хянан шийдвэрлэхэд цахим платформыг ашиглах бөгөөд тухайн платформын онцлог, тавигдах шаардлагын талаар зохицуулсан.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахимаар харилцахад төрийн байгууллагын албаны цахим шуудан, иргэний И-Монголиа өргөтгөлтэй цахим шуудан, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд холбогдсон цахим шуудан, хуулийн этгээдийн таньж, баталгаажуулах тохиргоо бүхий цахим шууданг ашиглана.
- Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчтэй харилцах, нотлох баримтыг хүлээн авах, үнэлэх, шүүх хуралдааныг явуулах, шийдвэрийг хүргүүлэх зэрэг шүүн таслах бүх ажиллагаанд хамаарна.

3. Шүүн таслах ажиллагаанд цахимжилт нэвтрүүлэхтэй холбогдуулан шүүгчийн мэдлэг, ур чадварыг сайжруулах, шинэ техник технологийг дасан зохицох, ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд шүүгчийг мэргэшүүлэн сургах тогтолцоог боловсронгуй болгох зүй ёсны шаардлага тулгарч байна. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн эрх зүйн байдал, тогтолцоог гадаад улсуудын ижил чиг үүрэг, түвшний шүүхийн сургалтын байгууллагын тогтолцоонд нийцүүлэн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи байхаар тусгав.

Шүүхэд цахимжилт нэвтэрч шүүхийн захиргааны хүний нөөцийг шуурхай удирдах, уян хатан зохицуулалтаар хангахад шүүхийн захиргааны байгууллага хүний нөөцийн бодлогоо бие даан хэрэгжүүлэх шинэлэг заалтууд Монгол Улсын шүүхийн тухай хуульд тусгагдсан.

4. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76.2, 95.4-т зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тавыг, Шүүхийн сахилгын хорооны гишүүний тавыг шүүгчид дотроосоо сонгодог болсноор шүүгч нь сонгогдон өөр ажил эрхэлж буй тухайн шүүхүүдэд мөн тооны орон тоо дутагдаж, шүүн таслах ажиллагаанд ачаалал үүсэж, шүүхийн үйлчилгээний шуурхай байдал хөндөгдөж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -д доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/31 дүгээр зүйлийн 31.1.6 дахь заалт:

"31.1.6.шүүгч бэлтгэх сургалтад хамрагдсан байх."

2/32 дугаар зүйлийн 32.2.4, 32.2.5 дахь заалт:

"32.2.4-давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчийн бүрэн эрх энэ хуулийн 39.1-д заасны дагуу түдгэлзсэнд тооцогдсон бол тухайн шүүхэд мөн тооны орон тоо нэмэх бөгөөд нэмсэн тухайн өдрөөс хойш 14 хоногийн дотор;

32.2.5-энэ хуулийн 76.2, 95.4-т заасны дагуу Ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны гишүүнээр тухай бүр буюу байнга сонгогдон ажиллах хяналтын шатны шүүхийн шүүгчийн тус бүр нэг орон тоо сул орон тоонд тооцогдох бөгөөд тухайн сул орон тоонд 14 хоногийн дотор."

3/43 дугаар зүйлийн 43.3.6 дахь заалт:

"43.3.6.шүүгч энэ хуулийн 76.2, 95.4-т заасны дагуу Ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж, дараагийн гишүүн сонгогдсоноор бүрэн эрхийн хугацаа дууссанаар урьд ажиллаж байсан шүүхэд эргэн ажиллах баталгаагаар хангагдах."

4/46 дугаар зүйлийн 46.9, 46.10 дахь хэсэг:

"46.9.Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаал, хууль мэргэжлээр болон тухайн шатны шүүхэд шүүгчээр ажилласан хугацаа харгалзан шүүгч Монгол Улсын шүүхийн тэргүүн түшээ, дэд түшээ, гутгаар түшээ, дөтгөөр түшээ, тавдугаар түшээ гэсэн зэрэг дэвтэй байх бөгөөд шүүгчид зэрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал батална."

46.10.Шүүгч энэ хуулийн 43.1-д заасан үндэслэлээр доод шатны шүүхэд шилжин томилгодох, энэ хуулийн 43.3-т заасан үндэслэлээр адил шатны шүүхэд сэлгэн ажиллах тохиолдолд түүний зэрэг дэв буурахгүй."

5/71 дүгээр зүйлийн 71.1.28-71.1.31 дэх заалт:

"71.1.28.шүүхээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах цахим платформ, программ хангамж, техникийн шаардлагыг хэрэг хянан

Шүүгчийнхүү хуульд заасны дагуу өөр ажилд тодорхой хугацаагаар томилогдон ажиллах тохиолдолд тухайн анхан, давж заалдах шатны шүүхэд мөн тооны орон тоо нэмэх замаар шүүхийн ачааллыг тэнцэржүүлж, шүүхийн үйлчилгээний шуурхай байдлыг хангахаар зохицуулна. Шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж, дараагийн гишүүн сонгогдсоноор бүрэн эрхийн хугацаа дууссанаар урьд ажиллаж байсан шүүхэд эргэн ажиллах баталгаагаар хангагдах шаардлагатай тул Монгол Улсын шүүхийн тухай хуулийн холбогдох хэсэгт нэмэлт оруулахаар боловсруулаа.

5.Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д зааснаар бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаал нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай албан тушаалд хамаардаг. Мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3-д "тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс" бүрдэхээр заасан бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүгчийн зэрэг дэвийн асуудлыг зохицуулаагүй орхигдуулсан тул шүүгчийн зэрэг дэвийн асуудлыг Монгол Улсын Их Хурал хуульд нийцүүлэн нарийвчлан тогтоохоор төсөлд тусгалаа.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д "... шүүгчийн туслах хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна" гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Монгол Улсын шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шүүхэд ажиллаж байгаа хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй шүүгчийн туслах Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89.1-д заасан шаардлагыг уг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд хангана" гэж заасан.

Шүүгчийн туслахын албан тушаалд эрх зүйч ажиллах боломжтой байсныг "хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан" хуульч ажиллахаар хуульчилсан нь бүх шатны шүүхэд шүүгчийн туслахын хомсдол бий болох шалтгааны нэг болсон.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй туслахуудын хувьд шүүхэд ажиллах орчин, нөхцөл муу, ажлын ачаалал их, байнга илүү цагаар ажиллаж байгаагаас шүүхээс бусад салбарт ажиллах сонголт хийж байна. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй захиргааны алба хаагч нар шүүхээс илүү орчин нөхцөл, зохист ачаалалтай хуулийн бусад байгууллагад ажиллах сонирхолтой болж, үнээс хамаарч шүүх хүний нөөцийн дутагдлаа 3-6 сар тутам нөхөх нөхцөл байдал үүсээд байна. Үүнээс хамаарч одоогийн нөхцөл байдлын хувьд, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсгийн "хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан" байх шаардлагыг хасах нь нэн яаралтай, зайлшгүй шийдэх асуудал болоод байгаа тул энэхүү заалтад өөрчлөлт оруулахаар төслийг боловсрууллаа.

шийдвэрлэх ажиллагааны холбогдох хуульд нийцүүлэн тодорхойлох, нэвтрүүлэх, хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах;

71.1.29.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөлжсөн цахим мэдээллийн санг нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй уялдуулан бүрдүүлэх;

71.1.30.хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

71.1.31.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх."

6/93 дугаар зүйлийн 93.3 дахь хэсэг:

"93.3.Шүүхийн захиргааны ажилтан энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн цахим мэдээллийн санд талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны бичлэгийг оруулах үүргээ биелүүлээгүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтан тухайн ажилтны зөрчлийн шинж байдлыг харгалзан үндсэн болон албан тушаалын цалинг 3 хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл ажлаас халах сахилгын шийтгэлийг оногдуулна."

7/101 дүгээр зүйлийн 101.6 дахь хэсэг:

"101.6.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулж болно."

2 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийн "зэргийн" гэсний дараа " зэрэг дөвийн" гэж, 71 дүгээр зүйлийн 71.1.9 дэх заалтын "үнөлэх" гэсний дараа " , давж заалдах, анхан шатны шүүхийн захиргааны ажилтны албан тушаалын цалингийн хэмжээг батлах, ажилтны ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнд суурилсан урамшууллыг батлагдсан цалингийн санд багтаан тогтоох" гэж, 76 дугаар зүйлийн 76.10 дахь хэсэг, 95 дугаар зүйлийн 95.10 дахь хэсэгт "зэрэг" гэсний дараа "дэв" гэж, 85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн "орон тоог" гэсний дараа " , албан тушаалын цалингийн хэмжээ" гэж, 102 дугаар зүйлийн 102.1.1 дэх заалт, 105 дугаар зүйлийн 105.3 дахь хэсэг, 113 дугаар зүйлийн 113.1 дэх хэсэг, 114 дүгээр зүйлийн 114.2 дахь хэсгийн "бичгээр" гэсний дараа " , буюу цаасан болон цахим хэлбэрээр" гэж, 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт "Өргөдөл, мэдээллийг амаар, эсхүл бичгээр болон цахимаар гаргаж болно." гэсэн хоёр дахь өгүүлбэр, 110 дугаар зүйлийн 110.2 дахь хэсгийн "шуудангаар" гэсний дараа "цахимаар," гэж, 112 дугаар зүйлийн 112.8 дахь хэсэгт "Гомдол, эсэргүүцлийг бичгээр буюу цаасан болон цахим хэлбэрээр гаргаж болно." гэсэн хоёр дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/- ийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дүрдсанаар өөрчлөн найруулсугай:

1/12 дугаар зүйл:

"12 дугаар зүйл.Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх

12.1.Шүүхийн үйл ажиллагааг хуульд зааснаас бусад тохиолдолд дараах байдлаар олон нийтэд нээлттэй, ил тод явуулна:

12.1.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг энэ хуульд заасны дагуу сонирхогч этгээд биечлэн болон цахимаар танилцах боломжийг бүрдүүлэх;

12.1.2.хуульд тухайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр энэ хуульд заасны дагуу шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэх;

12.1.3.талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны бичлэгийн цахим мэдээллийн сантай байх, тус сангийн мэдээллийг сонирхогч этгээд нээлттэй ашиглах боломж бүрдүүлэх.

12.2.Шүүх хуралдааныг хаалттай явуулснаас бусад тохиолдолд иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 10 өдрийн дотор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд ил тод, нээлттэй байршуулна.

12.3.Сонирхогч этгээд энэ хуулийн 12.1.1-д заасан мэдээлэлтэй биечлэн, эсхүл цахимаар танилцах журмыг Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн батална.

12.4.Сонирхогч этгээд болон хэвлэл мэдээллийн ажилтан, байгууллага энэ хуулийн 12.1.1-д заасан мэдээллийг бусдад түгээх бол эх сурвалжийг дурдаж, үнэн зөв, гуйвуулахгүйгээр түгээх үүрэг хүлээнэ.

12.5.Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст, эсхүл шүүхийн нээлттэй бусад цахим платформд заавал байршуулна.

12.6.Дараах шүүх хуралдааныг шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэнэ:

12.6.1.хяналтын шатны нээлттэй шүүх хуралдаан;

12.6.2.авлигын гэмт хэргийн анхан ба давж заалдах шатны нээлттэй шүүх хуралдаан.

12.7.Нээлттэй шүүх хуралдааны шууд дамжуулалт, дуу-дүрсний бичлэг дараах мэдээллийг агуулсан гарчиг, цахим холбоостой байна:

12.7.1.хуралдаанд оролцогч талуудын нэр;

12.7.2.хуралдаанаар хянан шийдвэрлэж байгаа асуудал, хэрэг, маргаан;

12.7.3.шүүхийн болон шүүх бүрэлдэхүүний нэр;

12.7.4.хуралдааны огноо.

12.8. Шүүх хуралдааныг дуу-дүрсний бичлэгээр дамжуулах тохиолдолд өөрчлөлт оруулах, хэсэгчлэн хасалт хийх, засварлахыг хориглоно.

12.9. Хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдааны явцын дууны, дуу-дүрсний бичлэгийг зохих журмын дагуу баталгаажуулан архивт хадгална.

12.10. Тухайн хэрэг хуваарилагдсан шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдааныг хуульд тухайлан зааснаас гадна дараах тохиолдолд хаалттай явуулахаар шийдвэрлэж болно:

12.10.1. шүүх хуралдааныг нээлттэй хийх нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журамд аюул учруулах эрсдэлтэй, нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуунд харш гэж үзсэн;

12.10.2. нийтийн ашиг сонирхол болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн;

12.10.3. талуудын хүсэлтээр шүүх хуралдааныг нээлттэй хийх нь хүний эрхэд аюул, эрсдэл учруулах, сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзсэн.

12.11. Авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 12.10 дахь хэсэг хамаарахгүй.

12.12. Шүүх хуралдааныг хаалттай явуулах тохиолдолд шүүх шалтгаан, тайлбар, үндэслэлийг шүүхийн цахим хуудаст байршуулж нийтэд мэдээлнэ.

12.13. Шүүх хуралдааныг хаалттай явуулахаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг шүүхийн цахим хуудаст байршуулснаас хойш 3 хоногийн дотор сонирхогч этгээд шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

12.14. Шүүх энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны бичлэгийг энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд төрөлжүүлэн архив, албан хэрэг хадгалалтын хугацааны турш хадгална.

12.15. Шүүхийн цахим хуудас, цахим мэдээллийн сангийн үйл ажиллагаа, түүнд мэдээлэл оруулах, байршуулах, шүүх хуралдааныг шууд дамжуулах болон олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэх, шүүхийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх журмыг Ерөнхий зөвлөл батална.

12.16. Хэргийн оролцогч буюу мэдээллийн эзэн, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нууцлах болон шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт гаргаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.

12.17. Мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болно.

12.18. Шүүхийн үйл ажиллагааг дараах байдлаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид цахимаар нээлттэй, ил тод байлгана:

12.18.1. хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас шүүхийн цахим платформд нэвтэрч, иргэн, захиргааны хэргийн материал, талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, хүсэлт, түүнд холбогдох нотлох баримт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамж, шийдвэртэй цахимаар танилцах боломжийг хангах, хуульд заасан мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл, баримт бичиг хүлээн авах, хүргүүлэх, харилцах боломжийг бүрдүүлэх;

12.18.2. зөрчил шалган шийдвэрлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагааны явцад хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас гаргасан хүсэлт, гомдлын шийдвэрлэлт, шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийдвэр, тогтоол, захирамж, шинжээчийн дүгнэлт, хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт болон хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагааны явцтай цахимаар танилцах боломжийг хангах, хуульд заасан мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл, баримт бичиг хүлээн авах, хүргэх, харилцах боломжийг бүрдүүлэх.

2/24 дүгээр зүйл:

"24 дүгээр зүйл. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи"

24.1. Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан шүүгч бэлтгэх болон шүүгчийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг судалгаа, мэдээлгээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи /цаашид "Шүүхийн академи" гэж Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.

24.2. Шүүхийн академи сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг бүхий бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөл, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн төлөөлөөс бүрдсэн орон тооны бус хороотой байна.

24.3. Шүүхийн академийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн танхимын саналыг харгалзан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална.

24.4. Шүүхийн академи энэ хуулийн 24.2, 24.3-т заасны дагуу батлагдсан хөтөлбөрөөр сургалт зохион байгуулж, шүүгчид багц цаг тооцох бөгөөд холбогдох бүртгэлийг Монголын хуульчдын холбоонд жил бүр хүргүүлнэ.

24.5. Шүүхийн академи анхан шатны шүүхэд нэр дэвшигч заавал хамрагдах шүүгч бэлтгэх сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулах бөгөөд холбогдох бүртгэлийг Ерөнхий зөвлөлд тухай бүр хүргүүлнэ.

24.6. Шүүхийн академийн захирал шүүгчдийн зөвлөгөөн болон шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн шүүгчийг нэг жил хүртэл хугацаагаар Шүүгчийн кәдемид шүүгч-сургагч багшаар ажиллуулж болох бөгөөд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно.

24.7. Зөвлөгөөн болон шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг зургаан сар хүртэл хугацаагаар Шүүхийн академид судлаачаар ажиллуулж болох бөгөөд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно.

24.8. Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар сургалтын хөтөлбөр, арга зүйд тусгахыг хориглоно."

3/89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг:

"89.1. Шүүгч туслахтай байх бөгөөд шүүгчийн туслах эрх зүйч мэргэжилтэй байна. Шүүгчийн туслах хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд албан тушаал дэвшүүлэх, цалингийн хэмжээг өөрчлөхөд харгалзах үндэслэл болно."

4/95 дугаар зүйлийн 95.17 дахь хэсэг:

"95.17. Сахилгын хороо ажлын албатай байх бөгөөд үйл ажиллагааны дүрэм, бүтэц, орон тоо, албан тушаалын цалингийн хэмжээг тус Сахилгын хорооны зөвлөгөөн батална."

4 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3, 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтын "Хүрээлэн" гэснийг "Шүүхийн академи" гэж, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсгийн "Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхтэй хамтран" гэснийг "Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академи" гэж, 71 дүгээр зүйлийн 71.1.28 дахь заалтын дугаарыг "71.1.32" гэж, 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсгийн "Магистраас дээш зэрэгтэй, харьцуулсан эрх зүйн судалгаа хийх чадвартай" гэснийг "шинжлэх ухааны судалгааны арга зүй болон гадаад хэлний зохих мэдлэгтэй" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.6 дахь заалтын "шүүгч болон" гэснийг хасуугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл, 2024.04.21

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт:

"11.1.5. албан тушаалын тодорхойлолтод тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсролын шаардлагад эрх зүйч мэргэжилтэй байхаар заасан шүүхийн захиргааны албан тушаал."

2/26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг:

"26.4. Шүүгч энэ хуулийн 44.7-д заасны дагуу Хуульчдын холбооны гишүүнчлэлээс түдгэлзсэн тохиолдолд энэ хуулийн 26.1.4-т заасан үргэлжилсэн сургалтад хамрагдах, багц цаг хангах үүргийг Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан шүүгчийг мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, мөн тооны багц цагийг хангаснаар биелүүлсэнд тооцно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл, 2024.04.21

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5.3 дахь заалтын "захиргааны" гэсний өмнө "шүүхийн захиргааны байгууллага, Шүүхийн сахилгын хорооны албан хаагчаас бусад" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл 2024.04.21

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН
АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангахад шаардагдах нэмэлт зардлыг санхүүжүүлж, шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

хөрвүүлж, албан тушаалтны цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ. Шүүхийн шатанд цахим баримт бичгээр хүргүүлэх боломжгүй цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны ажилтан цахим баримт бичигт хөрвүүлнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.2 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах

1. Төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулахаар хуульд заасан эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

2. Өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.

3. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.

4. Мэдээллийн эзэн завшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болно.

5. Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй.

6. Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонгоно.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

“3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна.”

2/1.16 дугаар зүйл

“1.16 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах

1. Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хавтаст хэрэг нь шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцсэн байна.

3. Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дүндэн систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.

4. Өмгөөлөгч тайлбар, гомдол, хүсэлт зэрэг баримт бичгийг цахим баримт бичгээр хүргүүлнэ. Техникийн шалтгаанаар ийнхүү хүргүүлэх боломжгүй тохиолдолд цаасан баримт бичгээр ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд техникийн боломжгүй байсан шалтгаанаа нотолж цахим баримт бичгээр нөхөн ирүүлж болно.

5. Мөрдөгч, прокуророос шүүхэд хүргүүлэх эрүүгийн хэрэг, баримт бичгийг шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцүүлж цахим баримт бичгийн хэлбэрт

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн доор дурдсан зүйл, хэсэгт дараах агуулгатай хэсэг, өгүүлбэр нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.5, 7.6 дахь хэсэг

"7.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүхийн мэдэгдэх хуудас, тэмдэглэл, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр зэрэг баримт бичгийг цахимаар хөтөлж, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, хуульд заасан бусад этгээдэд танилцуулах, гардуулах, эрх, үүрэг тайлбарлах ажиллагааг цахимаар явуулж болно.

7.6. Энэ хуулийн 7.5 дахь хэсэгт заасан баримт бичиг, тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гаргах нэхэмжлэл, хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, нотлох баримтыг хэргийн оролцогчид цахимаар танилцуулж болох бөгөөд эдгээр баримт нь шүүхийн цахим мэдээллийн системд тавигдах техникийн шаардлагад нийцсэн байна."

2/38 дугаар зүйлийн 38.11, 38.12, 38.13 дахь хэсэг

"38.11. Тоон гарын үсэг бүхий цахим баримтыг тоон гарын үсгийг эзэмшигч үйлдээгүй талаар үндэслэл бүхий тодорхой шалтгаан дурдаснаас бусад тохиолдолд уг цахим баримтын жинхэнэ эсэх талаар маргахгүй.

38.12. Шүүх зохигч аль нэг талын хүсэлтээр цахим баримт хуурамч эсэхийг тогтоохоор шинжээч томилох, хуурамч эсэх эргэлзээг арилгахаар бусад нотлох баримтыг шаардан гаргуулж болно.

38.13. Шүүх хуурамч цахим баримтыг нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх, эсхүл баримтыг төрийн эрх бүхий байгууллагад зайлшгүй шилжүүлэх шаардлагатайгаас бусад тохиолдолд хавтаст хэрэгт үлдэнэ. Шүүх энэ хуулийн 38.12-т заасан шинжээчийн дүгнэлтээр хуурамч гэж тогтоогдсон нотлох баримтын талаар прокурорын байгууллагад мэдэвлэнэ."

3/75³ дугаар зүйлийн 75³.4, 75³.5 дэх хэсэг

"75³.4. Энэ хуулийн 7.5, 7.6-д заасан, шүүхэд ирүүлсэн болон шүүхийн бэлтгэсэн цахим баримтыг шүүх хэвлэмэл байдлаар хадгална. Цахим баримтаас цаасан хавтаст хэргийг үүсгэхдээ баримт бичгийг шүүхэд ирүүлсэн, хэвлэсэн огноо, хэвлэсэн ажилтны талаарх мэдээллийг тухайн ажилтны тоон гарын үсгээр баталгаажуулан хавсаргана. Цахим баримт нь шүүхийн цахим мэдээллийн санд бичлэг хэлбэрээр байршсан бөгөөд мэдээллийн аюулгүй байдал баталгаатай хамгаалагдсан бол тухайн байдлаар нь хэрэгт хавсаргаж болно.

75³.5. Шүүх хавтаст хэргийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цахим хэлбэрээр эрхлэн хөтөлж болно. Цаасан хэлбэрээр шүүхэд ирүүлсэн баримтыг хэрэг хянан шийдвэрлэх цахим ажиллагаанд тавигдах техникийн шаардлагад нийцүүлэн хөрвүүлнэ. Цаасан баримтыг хөрвүүлсэн огноо, ажилтны талаарх мэдээллийг хавсаргаж, хөрвүүлсэн ажилтан тоон гарын үсгээр зурсан байна."

4/75⁶ дугаар зүйлийн 75⁶.4 дэх хэсэг

75⁶.4. Хэргийн оролцогч цахим баримтыг шүүхийн мэдээллийн системийн техникийн шаардлагыг хангуулан дараахийн аль нэг аргаар шүүхэд гаргаж болно:

75⁶.4.1. Шүүхийн мэдээллийн системд өөрийн эрхээр нэвтрэн байршуулах;
75⁶.4.2. Хэргийн оролцогч шүүхтэй харилцахаар сонгосон цахим шуудангийн хаяг;

75⁶.4.3. Энэ хуулийн 75⁶.2, 77.11-д заасан харилцаа холбооны хэрэгсэл;
75⁶.4.4. Эсхүл өгөгдлийг хадгалж, зөөвөрлөх боломжтой техник хэрэгсэл.

5/75³.1 дэх хэсэгт дараах агуулгатай нэгдүгээр өгүүлбэр

"Нэхэмжлэлийг цахимаар гаргаж болох бөгөөд цахим нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж буй этгээд тоон гарын үсэг зурсан байна."

6/75⁵.2 дахь хэсэгт дараах агуулгатай нэг, хоёрдугаар өгүүлбэр

"Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш энэ хуулийн 75⁵.4-т заасан хугацааны дотор нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зөвшөөрсөн, татгалзсан талаарх хариу тайлбараа бичгээр болон цахимаар гаргаж болно. Цахимаар гаргасан хариу тайлбарт хариуцагч, эсхүл түүний төлөөлөгч тоон гарын үсгээр зурсан байна."

7/77 дугаар зүйлийн 77.11 дэх хэсэг

"77.11. Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах

боломжтой бусад цахим систем, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглаж болно.”

8/96 дугаар зүйлийн 96.5, 96.6, 96.7, 96.8 дахь хэсэг

“96.5.Шүүх хуралдааны тэмдэглэлийг бичгээр хөрвүүлэх техникийн шаардлага хангасан байдлаар дуу-дүрсний бичлэгт буулгаж энэ хуулийн 96.2-т заасан хугацааны дотор цахим ба бичмэл тэмдэглэлийг бэлэн болгоно.

96.6. Шүүх хуралдаанаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дуу-дүрсний бичлэгт буулгах тохиолдолд тухайн ажиллагаа дуусмагц даруй хэрэг хянан шийдвэрлэх цахим ажиллагаанд тавигдах техникийн шаардлагад нийцүүлэн цахим ба бичмэл тэмдэглэлийг бэлэн болгоно.

96.7.Цахим тэмдэглэл болон бичмэл тэмдэглэлийг хэргийн материалын хавсаргана.

96.8.Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгчөөс бусад шүүх хуралдааны оролцогч цахим тэмдэглэлийг нээлттэй байлгахыг эс зөвшөөрснийг шүүх үндэслэл бүхий гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүх хуралдааны цахим тэмдэглэл даруй нийтэд нээлттэй байршина.”

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийг дор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“8 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

8.1.Хуульд өөрөөр заагаагүй бол бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

8.2.Хэргийн нотлох баримт, үйл явдал нь төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулна.

8.3.Хэргийн нотлох баримт, үйл явдал нь хүний эмзэг мэдээллээс бусад мэдээлэл болон байгууллагын нууцад хамаарах бол мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.

8.4.Мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болно.

8.5.Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй.

8.6.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан буюу мансуурсан, хэргийн оролцогч биш бол 18 насанд хүрээгүй этгээдийг шүүх хуралдааны танхимд байлгаж болохгүй. *

8.7.Шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр сургалтын зорилгоор багш, сурган хүмүүжүүлэгчийн удирдлагын доор шүүх хуралдаантай танилцаж байгаа 18 насанд хүрээгүй этгээдэд энэ хуулийн 8.6 дахь хэсэг хамаарахгүй.*

3 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75⁴ дүгээр зүйлийн нэрийг “Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх” гэснийг “Мэдэгдэх хуудас, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэл” гэж өөрчлөн найруулсугай.

4 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 754.2 дах хэсгийн “үндэсний цахим шуудангийн хаягаар” гэсний дараа “ өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шуудангийн хаягаар” гэж нэмсүгэй. хэлбэр

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

"3.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна."

2/2.1 дүгээр зүйлийн 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг:

"3.Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүргэх, хүлээн авах ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно."

4.Шалган шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцсэн байна."

5.Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, өмгөөлөгчдийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шуудан болон тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим системийг ашиглана."

6.Өмгөөлөгч тайлбар, гомдол, хүсэлт зэрэг баримт бичгийг цахим баримт бичгээр хүргүүлнэ. Техникийн шалтгаанаар ийнхүү хүргүүлэх боломжгүй тохиолдолд цаасан баримт бичгээр ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд техникийн боломжгүй байсан шалтгаанаа нотолж цахим баримт бичгээр нөхөн ирүүлж болно."

7.Эрх бүхий албан тушаалтан, прокуророос шүүхэд хүргүүлэх эрүүгийн хэрэг, баримт бичгийг шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцүүлж цахим баримт бичгийн хэлбэрт хөрвүүлж, албан тушаалтны цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ. Шүүхийн шатанд цахим баримт бичгээр хүргүүлэх боломжгүй цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны ажилтан цахим баримт бичигт хөрвүүлнэ."

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн "15.34 дүгээр" гэсний дараа "зүйл, 15.36 дугаар зүйл" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийг дор дурдснаар өөрчлөн найруулсугай:

"1.7 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нууцлал

1.Шүүгч, прокурор, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад олж мэдсэн хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх, түүнийг хамгаалах арга хэмжээ авна."

2.Шүүгч, прокурор, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаалтан нь хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцтай холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулж авна."

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө."

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

1/15.36 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль зөрчих

"1.Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагааны явцэд талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг гуйвуулан, ташаа байдлаар бүсдэд түгээсэн бол хүнийг нэг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг

"8.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөгдөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна."

2/10¹ дугаар зүйл

"10¹ дугаар зүйл.Шүүх захиргааны хэргийг цахимаар хянан шийдвэрлэх

10¹.1.Нэхэмжлэгч нэхэмжлэл гаргахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрээр явуулахаар сонгосон тохиолдолд шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн цахим системийг ашиглан явуулж болно.

10¹.2.Шүүх хэргийн оролцогчгүй, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчтэй/ харилцах, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, тайлбар, нотлох баримтыг хүлээн авах, мэдэгдэх хуудас, захирамж, шийдвэр, тогтоол болон бусад баримт бичгийг хүргэх, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан явуулах зэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим-платформ /шүүхийн мэдээллийн системийг/ ашиглан цахимаар явуулж-бөхнө на.

10¹.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь шүүхийн цахим-платформын /мэдээллийн системийн/ техникийн шаардлагад нийцсэн байна.

10¹.4.Өмгөөлөгч нэхэмжлэл, тайлбар, гомдол, хүсэлт зэрэг баримт бичгийг цахим баримт бичгээр шүүхэд хүргүүлнэ. Техникийн шалтгаанаар ийнхүү хүргүүлэх боломжгүй тохиолдолд цаасан баримт бичгээр ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд техникийн боломжгүй байсан шалтгаанаа нотолж цахимаар баримт бичгээр-нөхөн ирүүлж-бөхнө.- нэ.

10¹.5.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч нь нэхэмжлэл, /шаардлага/ тайлбар, гомдол, хүсэлт, нотлох баримтыг цахимаар баримт-бичгээр-ирүүлнэ. Ийнхүү ирүүлэх боломжгүй баримтыг шүүхэд цаасан хэлбэрээр ирүүлж, шүүхийн

захиргааны ажилтан хөрвүүлсэн огноо, ажилтны талаарх мэдээллийг хавсаргаж, тоон гарын үсгээр баталгаажуулна.

10¹.6. Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.

10¹.7. Шүүх хавтаст хэргийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цахим хэлбэрээр эрхлэн хөтөлж болно. Цаасан хэлбэрээр шүүхэд ирүүлсэн баримтыг цахим хавтаст хэргийн техникийн шаардлага хангасан хэлбэрээр хөрвүүлнэ.

10¹.8. Цахимаар хянан шийдвэрлэсэн хэргийн материалыг шүүх хэвлэмэл байдлаар хадгална. Цахим баримтаас цаасан хавтаст хэргийг үүсгэхдээ баримт бичгийг бэлтгэсэн, шүүхэд ирүүлсэн, хэвлэсэн огноо, үйлдсэн, хэвлэсэн хүний талаарх мэдээллийг хавсаргана. Цахим баримт нь шүүхийн цахим мэдээллийн санд бичлэг (tagging) хэлбэрээр байршсан бөгөөд мэдээллийн аюулгүй байдал баталгаатай хамгаалагдсан бол тухайн байдлаар нь хэрэгт хавсаргаж болно.

3132 дугаар зүйлийн 32.9, 32.10, 32.11 дэх хэсэг

32.9. Цахим баримтыг шүүхэд мэдээллийн сүлжээ болон тэдгээрийг хадгалж, зөөвөрлөх боломжтой техник хэрэгслээр дамжуулан гаргаж өгнө.

32.10. Шүүх цахим хэлбэрээр ирүүлсэн баримттай холбогдуулан эх хувийг шаардах, шинжилгээ хийлгэх, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа хийх болон бусад нотлох баримтыг шаардан гаргуулж болно.

32.11. Шүүх хуурамч нь тогтоогдсон цахим баримтыг нийтийн эрх ашигт сөрөөр нөлөөлөх, эсхүл нийтийн эрх зүйн бусад этгээдэд тухайн баримтыг ишлжүүлэх зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хавтаст хэрэгт үлдээнэ. Шүүх хуурамч нотлох баримтын талаар прокурорын байгууллагад мэдээнэ.

41 42 дугаар зүйлийн 42.9., 42.10., 42.11 дэх хэсэг

42.9. Шүүх хуралдаанаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн дуу-дүрсний бичлэгт буулгах тохиолдолд тухайн ажиллагаа дуусмагц даруй техникийн шаардлага хангасан байдлаар цахим ба бичмэл тэмдэглэлийг бэлэн болгоно.

42.10. Дуу-дүрсний бичлэгт буулгасан цахим тэмдэглэл болон түүнийг хөрвүүлсэн бичмэл тэмдэглэлийг хэргийн материалд хавсаргана.

42.11. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч цахим тэмдэглэлийг нээлттэй байлаахыг эс зөвшөөрснийг шүүх үндэслэл бүхий гэж үзсэнээс бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим тэмдэглэл даруй нийтэд нээлттэй байршина.

5159 дүгээр зүйлийн 59.12 дахь хэсэг

59.12. Шүүх цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа тохиолдолд мэдэгдэх хуудсыг хуулийн 10¹.6.-д заасны дагуу хүргүүлнэ.

61106 дугаар зүйлийн 106.9 дэх хэсэг

106.9. Хэргийг цахимаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд шүүх шийдвэртээ Цахим гарын үсгийн тухай хуульд заасан журмын дагуу цахим гарын үсэг хэрэглэж болно.

2 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн "бичгээр" гэсний дараа "эсхүл цахим хэлбэрээр" гэж, 52.4 дэх хэсгийн "нэхэмжлэлийг" гэсний өмнө "Цаасан хэлбэрээр гаргасан" гэж, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн "гардуулна" гэсний дараа "Цахим нэхэмжлэлийг харууцагчид энэ хуулийн 10¹ дугаар зүйлийн 10¹.1-д заасны дагуу гардуулна" гэж, 57.2 дахь хэсгийн "ирүүлнэ." гэсний дараа "Цахимаар гаргасан харуу тайлбарыг тоон гарын үсгээр баталгаажуулна." гэж, 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсгийн "үүрэгтэй" гэсний дараа "Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхээс цахим системээр мэдэгдэл илгээснээр товч мэдэгдсэнд тооцно" гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн "бичиг" гэсний дараа "хэлбэр" гэж, 70.1.1 дэх заалтын "нотлох баримт" гэсний дараа "гаргуулах" гэж, 108.4 дэх хэсгийн "гардан авна." гэсний дараа "Цахимаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 10¹ дугаар зүйлийн 10¹.1-д заасны дагуу гардуулна" гэж, 114.6 дахь хэсгийн "114.1" гэсний өмнө "113.2" гэж, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийн "65.1" гэсний дараа "109.2" гэж, "111.3" гэсний дараа "114.6" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийг дор дурдснаар өөрчлөн найруулсугай:

119 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

9.1. Хуульд өөрөөр заагаагүй бол бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

9.2. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлээс бусад мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, гэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.

9.3. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулна.

9.4. Мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болно.

9.5. Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задрүүлж болохгүй.

9.6. Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан буюу мансуурсан, хэргийн оролцогч биш бол 18 насанд хүрээгүй этгээдийг шүүх хуралдааны танхимд байлгаж болохгүй.

9.7. Шүүх хуралдаан дэргалагчийн зөвшөөрлөөр сургалтын зорилгоор багш, сурган хүмүүжүүлэгчийн удирдлагын доор шүүх хуралдаантай танилцаж байгаа 18 насанд хүрээгүй этгээдэд энэ хуулийн 9.6 дахь хэсэг хамаарахгүй."

2/ 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг

96.1 "Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшуулах бөгөөд нотлох баримттай холбоотойгоос бусад асуудлын талаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаасан хүсэлтийг сонсмогц шүүгч, шүүх бүрэлдэхүүн даруй шийдвэрлэнэ. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлаар шүүх хуралдаан дээр дахин хүсэлт гаргах эрхгүй"

4 дүгээр зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийн "цахим шуудан" гэснийг "энэ хуулийн 59.12-т заасны дагуу гэж", "шаардлагатай тохиолдолд" гэснийг "эсхүл" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.4 дэх заалтын "байгууллага," гэснийг, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийн "50.4-т зааснаас бусад тохиолдолд" гэснийг, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгээс "нэхэмжлэл бүртгэх дэвтэрт", 75 дугаар зүйлийн 75.2.6, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх хэсгийн "энэ тухай бичгээр" гэдгийн "бичгээр" гэснийг, 96 дугаар зүйлийн 96.2 дахь хэсгийн "Шүүх хуралдааны явцад нэмэлт нотлох баримт зайлшгүй шаардлагатай болсон, эсхүл" гэснийг, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн "байгууллагын нууц," гэснийг, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийн "32.6" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тоолсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Санал. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хуульд цахимжилттай холбогдуулсан оруулсан өөрчлөлтийг тодорхой хугацаа зааж, үе шаттайгаар хэрэгжүүлэхээр зохицуулах.